

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

2021 оны 12 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай болон Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон Цагдаагийн байгууллагын эрхэм зорилго, зорилт, хөгжлийн хөтөлбөр, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, сонгон шалгаруулах, бүрдүүлэх, бэлтгэх, хуваарилах, үнэлэх, оновчтой байршуулах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгох зорилгоор Цагдаагийн байгууллагын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/199 дүгээр тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ онд шинээр 1296, төрийн бусад байгууллагаас шилжүүлэн 27, дэвшүүлэн 1114, шилжүүлэн 1494 алба хаагчийг томилж, цэргийн алба хаасны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 248, хүүхэд асрах чөлөө олгож 108, төрийн бусад байгууллагад шилжүүлэн ажиллуулахаар 48, сургалтад хамруулахаар 19, чөлөөлөгдөх хүсэлтээр гаргасан 242, бусад үндэслэлээр 2 алба хаагчийг чөлөөлж, гэмт хэрэг үйлдэж шүүхээр тогтоогдсон 7, өргөсөн тангараг, ёс зүй, сахилгын дүрэм ноцтой зөрчсөн 27, цагдаагийн байгууллагад 1 жилийн хугацаанд орох эрхгүй 100 алба хаагчийг халах сахилгын шийтгэл оногдуулсан.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагад 650 орон тоог нэмэгдүүлсэнийг хүүхдийн байцаагчийн 103, хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаагийн 281, эргүүл, жижүүрийн 70, зохицуулагч 50, эрүүгийн мөрдөгч 10, мөрдөгч 17, сэтгэл зүйч 20, холбоо мэдээллийн инженер 20, дотоодын цэрэгт 79 орон тоог хуваарилж, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.1, 2.3-т заасныг үндэслэн албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нөхөн хангалтыг 90 орчим хувьтай гүйцэтгэсэн.

Шинээр нэмэгдсэн орон тоог хуваарилж, алба хаагчдыг томилохын зэрэгцээ зарим нэгжийн бүтцэд өөрчлөлт орууллаа. Тухайлбал:

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд “Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс”, Тээврийн цагдаагийн албанд “Зөрчил шалгах хэлтэс”, “Замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс /гэрээт/”, “Мэдээлэл, технологийн тасаг”, Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтэст “Эмнэлэг, сэтгэл зүйн хэсэг”, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газарт “Шөнийн эргүүлийн хэлтэс”-ийг байгуулсан.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”, Тээврийн цагдаагийн албаны Захиргааны удирдлагын газрын Урьдчилан сэргийлэх хэлтэст хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан “Ахлах мэргэжилтэн” тус бүр 2, Мөрдөн байцаах албаны бүтцэд “Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс”, Нийслэлийн дүүрэг дэх цагдаагийн газарт “Чиглэлийн ахлах мэргэжилтэн /Гэр бүл, хүүхэд, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан/” тус бүр 1, нийт 12 орон тоог шинээр, аймаг, нийслэл дэх цагдаагийн газар, хэлтсүүдэд 82 чиглэлийн ахлах мэргэжилтэн /Урьдчилан сэргийлэх, гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан/, хүүхдийн асуудал

хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн орон тоотойгоор тус тус шинээр байгуулснаар Монгол улсын Хүүхэд хамгааллын хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдахад ахиц гарч, эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдийг олж илрүүлэх, хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой болсон.

Сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Дотоод хэргийн Их сургуультай хамтран “Цагдаа”, “Цагдаа жолооч”, “Харуулчин” мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтыг 5 удаа зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 1402 иргэнийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2021 оны 01, 05, 06, 08, 09 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ алба хаагчийн нөөцийн жагсаалт”-д бүртгэн, мэргэжил олгох сургалтад 921 иргэнийг хамруулж, 2018, 2018, 2020, 2021 оны нөөцөд бүртгэлтэй иргэдээс энэ онд 996 иргэнийг, Цагдаагийн байгууллагын захиалгаар элсэн суралцаж, 2020-2021 оны хичээлийн жилд “Цагдаагийн ажил-эрх зүй” мэргэжлээр төгсч байгаа 273 төгсөгчийг “Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөц”-д бүртгэн ажлын байр /албан тушаал/-ны сул орон тоонд онооны дарааллыг баримтлан тус тус томилж, нөхөн хангалтыг тасралтгүйгээр зохион байгуулан, нэгжийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж байна.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2021 онд ахлагчаас офицер албан тушаалд 467, ахлах албан тушаалд 499, чиглэлийн ахлах албан тушаалд 75, тасаг, хэсгийн даргын албан тушаалд 141, алба, газар, хэлтсийн даргын албан тушаалд 118, нийт 1300 алба хаагчийг дэвшүүлэх нөөцийн жагсаалтад бүртгэж, цагдаагийн байгууллагын цахим санд байршуулан, тус нөөцөөс 526 алба хаагчийг дэвшүүлэн томилж, шийдвэрлэсэн.

Төрийн одон, медалиар 60, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 721, Цагдаагийн байгууллагын хүндэт ажилтан тэмдэг 1, “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 395, “Дотоодын цэргийн алдар” тэмдгээр 8, “Цагдаагийн төлөө” тэмдгээр 16, “Монгол цагдаа” тэмдгээр 195, “Хүндэт жуух”-аар 505, “Албаны төлөө” зэргийн тэмдгээр 1326, эрүүгийн цагдаагийн хүндэт ажилтан тэмдэг 17, спортын алдар тэмдгээр 29, нийт 3273 ажилтан, алба хаагч шагнагдсан нь нийт алба хаагчдын 29.7 хувийг эзэлж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйл, Дотоодын цэргийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасныг баримтлан нийт 2938 алба хаагчид хугацааны цол олгосон.

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР